



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 13

Өлгий

Аймгийн төр захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын удирдах ажилтны 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит шуурхай хуралдааны тэмдэглэлээс:

Нэг. Аймгийн Засаг дарга А.Гылымхан дараах үүрэг даалгаврыг өгөв. Үүнд:

1.1. Багшаар ажиллах эрх олгох шалгалтад оролцогчдын ихэнх нь тэнцээгүй гэж мэдээллээ. Цаашид багш мэргэжлээр төгсөж буй хүүхдүүдийн дунд судалгаа хийж, дүгнэлт гарган, ихэвчлэн ямар сургуулиас төгссөн хүүхдүүд шалгалтад тэнцээгүй байгааг тогтоож, тухайн сургуультай хамтарч ажиллах санал тавих хэрэгтэй. Мөн аймагт багшаар ажиллах эрх олгох шалгалтад бэлтгэх, зааж сургах багш бэлтгэж сайжруулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга Х.Зауред,

1.2. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа өнөөдөр эхэлж байна. Энэ удаагийн судалгааны үр дүнг үндэслэн төрөөс үзүүлэх нийгмийн тусламж, үйлчилгээнд хамруулах зорилтот бүлгийг сонгоход чиглэж байгаа тул зайлшгүй хамрагдах шаардлагатай айл, өрхүүд бүгд хамрагдах ёстойг онцгой анхаарч, судалгааны явцад хяналт тавьж, сум, багийн Засаг дарга нартай нягт холбоотой ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Б.Сьезханд,

1.3. Аймгийн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын асуудлыг эмх цэгцэд оруулах ажлын хүрээнд төлөвлөгөөг зөрчиж онцгой бүсээс хууль бус газар эзэмшиж буй иргэдийн асуудлыг шийдэх, тухайлбал онгоцны хөөрч буух аюулгүйн бүсэд газар олгосон зэрэг асуудлуудыг зохих журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авч байгааг ард иргэдэд зөвөөр ойлгуулж, энэхүү ажлыг зохих хууль, журмын дагуу зохион байгуулах, мөн ажлын хэсэг гаргаж, төв талбайн хойд талд баригдах барилгын зурагт төсөвтэй танилцаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх арга хэмжээ авахыг Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын дарга К.Болатад,

1.4. Иргэн бүрийн хуулиа дээдлэх, сахин биелүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэх, хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор "Хуулиа дээдэлье" аяныг аймгийн нийт сум, төрийн байгууллагуудын дунд зохион байгуулж эхэллээ. Энэхүү арга хэмжээний дагуу бүх салбарыг хамруулсан жилийн төлөвлөгөө гаргасан. Уг төлөвлөгөөг үндэслэн байгууллага бүр төлөвлөгөө гаргаж, албан хаагчдын ёс зүй, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх ажил зохион байгуулж, идэвхтэй оролцохыг хэлтэс, агентлагийн дарга нарт,

1.5. Ойрын өдрүүдэд их цас орсны улмаас зарим сумдын зам, даваа хаагдсан өнөөдрөөс замыг цэвэрлэх, нээх ажлуудыг шуурхай хийгдэж байна. Хаврын улирал бол цаг агаарын хувьд тогтворгүй улирал төл мал хүлээн авах бэлтгэлээ малчид өөрсдөө сайн базаах шаардлагатай талаар сумдын удирдлага болон мал эмнэлгийн

мэргэжилтнүүдэд чиглэл хүргүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Ерболатад,

1.6. Жижиглэнгээр савлан борлуулж байсан самарнаас шавьж илэрсэн асуудлын тухайд, цаашид гарал үүсэл нь тодорхойгүй, сав, баглаагүй зүйл борлуулахгүй байх, мөн энэхүү самар нь аль хилээс орж ирсэн, зөвшөөрөл, сертификат байгаа эсэхэд шалгалт хийж, дүгнэлт гаргаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Мухамедэд,

1.7. Өлгий сумын удирдлагууд болон хот тохижуулах албаныхан дотоод ажлаа зөв зохион байгуулж, хот тохижуулах ажлыг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгов.

Хоёр. Аймгийн Засаг даргын орлогч А.Камелият дараах үүрэг даалгаврыг өгөө.
Үүнд:

2.1. Байгууллагууд эхний улирлын тайлан мэдээг гаргаж, ЗДТГ-ын харьяа хэлтсүүдэд ирүүлэхийг засаг даргын дэргэдэх агентлагуудад,

2.2. Улсын төсвийн тодотгол хийгдэж, зарим салбарт төсөв нэмэгдэж байгаатай холбогдуулан дээд байгууллагадаа асуудал тавьж албан тоот боловсруулан хүргүүлж, орон нутгийн эдийн засгийн чадавхийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр идэвх санаачлагатай ажиллахыг нийт төсөвт байгууллагын дарга, удирдлагуудад,

2.3. Иргэн бүр өөрийн хэрэгцээт үйлчилгээг төрөөс авдаг, тухайн үйлчилгээ нь ямарваа хүнд суртал, чирэгдэлгүй байх ёстой. Зарим байгууллагын дарга, мэргэжилтнүүдийн ёс зүй, үйлчилгээ үзүүлж буй байдлын талаар иргэдээс гомдол ирсэн. Иймд төрийн үйлчилгээ үзүүлж байгаа төсөвт байгууллагууд иргэдэд зөв боловсон үйлчилгээ үзүүлж ажиллахыг хэлтэс, агентлагийн дарга, удирдлагуудад тус тус үүрэг болгов.

Дээрх үүрэг даалгаврын дагуу хийгдсэн ажлын талаарх мэдээг 04-р сарын 6-ны өдөр Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст бичгээр болон цахим хаягаар ирүүлж ажиллахыг холбогдох хэлтэс, агентлагийн дарга нарт даалгав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР